



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/118

Мандалговь

Тэнгэрлэг-Ой ХХК-тай гэрээ
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Хамгаалалтын ойн зурвас байгуулах /Эрдэнэдалай сум/”-ын гүйцэтгэгчээр шалгарсан “Тэнгэрлэг-Ой” ХХК-тай 86,900,000 (наян зургаан сая есөн зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Ажлын даалгаврын дагуу ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тэнгэрлэг-Ой” ХХК-ний захирал (О.Оюун)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150275